Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний
өдрийн 09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг баталсан холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/93 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэд Ёс зүйн хороог байгуулан салбарын хэмжээнд нийт 31 Ёс зүйн дэд хороо, 123 гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо нь дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд: -Нийгмийн даатгалын ерөнхий газрын ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан заримыг үндэслэн “Төрийн албан хаагчид бид” постер, ийг хийж Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 30 салбар нэгжийн цахим сайтаар дамжуулан ёс зүйтэй төрийн албан хаагч байхаа иргэд, даатгуулагчдад илэрхийлэх; -Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргэх арга хэмжээний хүрээнд зөвлөмж, чиглэлийг хүргүүлэх; - Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав. Уг хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт нийт 7 удаагийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 380, цахимаар 950 гаруй албан хаагчийг хамруулав. -Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд нийт 17 гомдол мэдээлэл ирүүлсэн бөгөөд үүнээс 10 гомдол, мэдээлэл нь ёс зүйн зөрчилгүй, 7 гомдол мэдээлэл нь зөрчилтэй талаар дүгнэлт гаргаж, 1 албан хаагч сайн дураар хариуцлагаа хүлээж албан тушаалаас чөлөөлөгдсөн, 3 албан хаагчид хариуцлага ногдуулж, 2 албан хаагчид хариуцлага ногдуулахаар Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа явуулж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргэх арга хэмжээний хүрээнд дараах зөвлөмж чиглэлийг хүргүүлээд байна. Үүнд: • Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөж, төрийн албан хаагчийн ёс зүйг сахих, зан харилцаа, хандлагаараа хамт олноо үлгэрлэн, иргэдэд хүндэтгэлтэй хандаж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэж ажиллах, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдээс иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, цуцлах үйл ажиллагааг явуулахдаа иргэдтэй зохисгүй харьцах, зан харьцааны зөрчил гаргах, маргалдах асуудал цаашид ч гарах магадлалтай тул хурлын танхимд камер байршуулж хурлын явцад хяналт тавих, камерын бичлэгийг тодорхой хугацаанд хадгалж,

Scanned with CamScanner

архивлах боломжийг бүрдүүлэх талаар салбар зөвлөлүүддээ албан ёсоор чиглэл өгч ажиллахыг Ёс зүйн дэд хорооны даргын 04/1103, 04/1102 албан бичгүүдээр;

- Архангай аймгийн Нийгмийн даатгалын газарт Ёс зүйн дэд хороог байгуулахдаа 6 гишүүнтэйгээр жил бүр шинэчлэн баталж байгаа нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам зөрчсөн байх тул Ёс зүйн дэд хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дахин байгуулах, дахин байгуулахдаа нийт албан хаагч нар бүгд нэр дэвшигч байх, санал хураалтад оролцуулан байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 04/2845 дугаар албан бичгээр;
- Нийгмийн даатгалын салбарын нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, томилох эрх бүхий албан тушаалтнуудтай 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж Нийгмийн даатгалын салбарт гарч байгаа ёс зүйн зөрчил, Ёс зүйн дэд хороодын нийтлэг гаргаж байгаа алдаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх, дотоод зохион байгуулалт хийж ажиллах талаар чиглэл өгөв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав. Уг хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт нийт 7 удаагийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 380, цахимаар 950 гаруй албан хаагчийг хамруулав.

“Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2018 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар хүчингүй болгосон бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотой Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагч нарын буюу “Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлахаар дүрмийн төсөл боловсруулан санал авахаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн дарга нарт тус тус хүргүүлээд байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-нд 2025 онд нийт 9 гомдол, мэдээллийг иргэд, төрийн албан хаагчдаас ирүүлсэн ба үүнээс 3 гомдлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны харьяалан шийдвэрлэх гомдол биш байх тул харьяаллын дагуу буюу Орхон, Дархан-Уул, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороодод шилжүүлсэн. Харин 4 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хороо гомдлыг хүлээн авч, төрийн албан хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг шаардлага, хориглолтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргасан.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Нийгмийн даатгалын ерөнхийн газрын дарга болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нар өөрийн эрх хэмжээний хүрээнд Ёс зүйн дэд хороог тушаалаар албажуулах, Ёс зүйн дэд хорооноос хүргүүлсэн дүгнэлтийн дагуу төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх, Дэд хорооны гишүүдэд олгох урамшууллыг батлагдсан төсвийн хүрээнд олгох ажлыг зохион байгуулсан бөгөөд Нийгмийн даатгалын албан хаагчдад зориулсан сургалтыг дэмжих, сургалт зохион байгуулах боломж нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд сургалтад хамрагдсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу цалинтай чөлөө олгох, техник хэрэгслээр ханган ажиллав.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааа:

Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хороод дараах арга хэмжээг хуульд нийцүүлэн зохион байгуулав. Үүнд:

Scanned with CamScanner

-Нийгмийн даатгалын салбарын 31 Ёс зүйн дэд хороод 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд батлан хэрэгжүүлэв.

-Нийгмийн даатгалын ерөнхий газраас салбарын хэмжээнд сургалт, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд өөрийн харьяалах төрийн албан хаагч нарт сургалт зохион байгуулав.

-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актын хэрэглээний талаарх сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны гишүүд, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг тус тус хамруулав.

-Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн онцлог заалтуудаар постер бэлтгэн албан хаагчдад, болон иргэд, даатгуулагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан ажиллав.

-Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагч нар өөрийн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх үедээ буюу шийдвэр гаргахдаа ёс зүйн зөрчил гаргах эрсдлийг тогтоох 10 асуулт бүхий судалгааг авч ажилласан. Судалгаагаар Нийгмийн даатгалын салбар дунджаар 92 оноогоор буюу эрсдэл бага гэж үнэлэгдсэн болно.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл
Салбарын хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актуудыг танилцуулсан, төрийн албан хаагчийн ёс зүйн талаар ойлголттой болсон төдийгүй бусад Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасан зарим заалтаас ялгаатай шинж байдлыг ялгах, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан зөрчлийн шинж байдлыг ялгах, тогтооход сургалцсан. Мөн өөрийн байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг тогтоох нь чухал ба түүнээс шалтгаалан соён гэгээрүүлэх арга хэмжээг төлөвлөх чухал байна.	-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасан урамшууллаар бүрэн хангагдах. -Ёс зүйн хорооноос гаргасан эрх зүйн акт хэм хэмжээний улсын бүртгэлт бүртгэгдээгүй байх. -Гомдолд холбогдогч Төрийн албан хаагчдад дүгнэлттэй холбоотой гомдол гаргах эрх хязгаарлагдмал.

Санал:
Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгохоор хуульчилсан тул олгох талаар эрх бүхий байгууллагад уламжлах, Төрийн албан хаагчийн ёс зүйн түвшинг үнэлэх судалгааны арга зүйн, ном, гарын авлага, сургалтыг зохион байгуулах.

Шалгах хэсэг

☐ “Ёс зүйн сахилга, хариуцлага шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

Scanned with CamScanner

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө, хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу хавсаргасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ

Томилох эрх бүхий албан тушаалтан

Дарга		Б.Батгарал
Албан тушаал	Гарын үсэг	Газрын үсгийн тайлал

Ёс зүйн дэд хорооны дарга

БХТГ-ын дарга		Ц.Гонгор
Албан тушаал	Гарын үсэг	Газрын үсгийн тайлал

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Ахлах мэргэжилтэн		М.Гэрэлмаа
Албан тушаал	Гарын үсэг	Газрын үсгийн тайлал

Scanned with CamScanner

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН 2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Албал зохих оноо	Оноо [1]	Хувийн жин [2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	0,97	9,7
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0,82	8,2
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0,45	4,5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0,5	0,5	5
Хэсгийн оноо				4	3,74	37,4
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	0,99	9,9
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0,94	9,4
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0,34	3,4
Хэсгийн оноо				3	2,27	22,7
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	10	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	0,94	9,4
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	0,94	9,4
Хэсгийн оноо				3	2,98	28,8
Үнэлгээний нийт оноо хувь				10	8,89	88,9

Scanned with CamScanner

БАТЛАВ:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.03.20

Д/д	Арга хэмжээ	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах гишүүн
1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын "Ёс зүйн дэд хороо"-нд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, дүгнэлт гаргах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, гомдол мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу шалган хуралдаанаар хуульд заасан хугацааны дотор хэлэлцэн дүгнэлт гаргасан гомдол мэдээллийн тоо байна.	Тухай бүр	Бүх гишүүд
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга, постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хаяг болон харьяа Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн түгээх	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар уриалга, постерийг улиралд 2-оос доошгүй удаа гарган, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хаяг болон харьяа Нийгмийн даатгалын газруудад хүргүүлж түгээсэн байна.	Улирал бүр	Д.Тэмүүжин, Мө.Гэрэлмаа
3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайлан, Дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн тайланг Ёс зүйн хорооны баталсан маягтын дагуу улирал бүр, Дэд хорооны үйл ажиллагааны тайланг дараа оны нэгдүгээр улиралд батгаан Ёс зүйн хороонд хүргүүлсэн байна.	Улирал бүр	Мө.Гэрэлмаа
4	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргэх	Харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөмж, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө хүргүүлсэн тоо байна.	Тухай бүр	Бүх гишүүд

Scanned with CamScanner

	түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх сургалт, Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд "Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах" мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах	түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын талаарх сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.		Мө.Гэрэлмаа
6	"Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж батлуулах	"Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн байна.	IV улиралд	Ма.Гэрэлмаа Б.Даваахүү Мө.Гэрэлмаа
7	Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан албан хаагчийн ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудын ёс зүйн байдлыг тогтоох судалгаа авах, судалгааны дүнг гаргах, санал боловсруулан танилцуулах.	II улиралд	Д.Тэмүүжин, Мө.Гэрэлмаа
8	Ёс зүйтэй төрийн албан хаагчийг шалгаруулж, нийтэд зарлах арга хэмжээ зохион байгуулах	Төлөвлөгөөний долоо дугаар арга хэмжээний дүнд үндэслэн Ёс зүйтэй төрийн албан хаагчийг шалгаруулан нийт албан хаагчдын өмнө урамшуулсан байна.	III улиралд	Ц.Ганцэцэг, Мө.Гэрэлмаа
9	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох баримт бичгийг архивын асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгөх, харьяа Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороонд арга зүйн зөвлөгөө хүргэх	Гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох баримт бичгээр архивын хадгаламжийн нэгж бүрдүүлсэн байна.	IV улиралд	Мө.Гэрэлмаа
10	Нийгийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулах	Нийгийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтнуудад Ёс зүйтэй ажиллах, манлайлах, хуульд заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр сургалт зохион байгуулах.	III улиралд	Б.Зул, Мө.Гэрэлмаа

Scanned with CamScanner